

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/275
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЬЯА ҮНДЭСНИЙ АВРАХ
БРИГАДЫН ДАРГА, ХУРАНДАА
Д.НАМСРАЙ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2019\0225SAG40.Docx


070674

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үндэсний аврах бригадын захирагч, хурандаа Д.Намсрай Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 18-наас 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 22 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний аврах бригад 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 17/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Үндэсний аврах бригад нь Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, аюулгүй газарт зөөвөрлөн гаргах, эд хөрөнгийг авран хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх,
- Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах,
- Гамшигт нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх,

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, хууль, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндэсний аврах бригад санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар сонгов.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь 4,792,778.8 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 95,855.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(мянган төгрөгөөр)
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	61,928.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	61,928.4	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Бараа материалын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 2,500.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан.

2. Жилийн эцэст 148,506.8 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийсэн боловч үр дүнг баталгаажуулаагүй

3. Төсвийг үндэслэлгүй төлөвлөснөөс НДШ-ийн зардлын төсөв 80,509.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн,

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дээр дурдсан нийт 231,516.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ОБЕГ-ын харъяа Үндэсний аврах бригадын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,947,725.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,793,749.2 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 146,121.6 мянган, байр ашиглалтын зардал 3,264.8 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 4,588.4 мянган, эд хогшил худалдан авах зардал 1,800.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсанаас шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Үндэсний аврах бригад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд 148 мэдээлэл оруулснаас 109-ийг нь хуулийн хугацаанд, 39-ийг нь хугацаа хоцроож оруулсан байна. Албан хаагчдад зориулсан мэдээллийн самбарт байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, цалингаас бусад 5.0 сая төгрөгнөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, бусад мэдээллийг байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв, гүйцэтгэл

1.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлыг шалгаж үзэхэд 30,445.4 мянган төгрөгийг спортын мастерын нэмэгдэлд үндэслэлгүйгээр олгосон, өөрийн орлогыг зарцуулахдаа 19.109.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүйгээс гадна Спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дахь заалттай нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл:

Батлагдсан төсөв, өөрийн орлогыг үнэн зөв, зориулалтын дагуу зарцуулаагүй байх,

1.3 Зөвлөмж:

Үндэслэлгүй нэмэгдэл олгохыг зогсоох, өөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах,

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

2. Санхүүгийн тайлангийн тодруулга

2.1 Илрүүлэлт:

Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас 4,304.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тооллогоор дутагдсан 7.236.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлээгүй,

Энэ нь ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4 дахь заалттай нийцэхгүй байна.

2.2 Эрсдэл:

ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр хөрөнгө бэлтгэсэн байх,

2.3 Зөвлөмж:

Хөрөнгө бэлтгэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч байх, тооллогоор дутагдсан хөрөнгийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээр дурдсан алдаа, зөрчлийг Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тулган баталгаажуулахад 832.8 мянган төгрөгийн авлагыг холбогдох байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,

Энэ нь Төсвийн тухай хулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл:

Өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх,

3.3 Зөвлөмж:

Өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх,

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээр дурдсан алдаа, зөрчлийг Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,223,196,854.00</u>	<u>1,569,136,680.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,749,316.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	4,749,316.00
31130	Нэмэлт санхүүжилт		4,749,316.00
33	АВЛАГА	-	832,800.00
335	Бусад авлага	-	832,800.00
3351	Байгууллагаас авах авлага		832,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,221,618,018.00	1,563,554,564.30
351	Түүхий эд материал	14,785,584.90	73,301,992.40
35110	Тусгай зориулалттай материал	10,194,900.00	68,177,796.38
35130	Эм боох материал	4,590,684.90	5,124,196.02
354	Хангамжийн материал	1,204,722,433.10	1,486,907,571.90
35410	Бичиг хэргийн материал	3,968,618.00	6,260,616.00
35420	Аж ахуйн материал	34,800,557.98	49,448,723.98
35430	Сэлбэг хэрэгсэл	894,570.00	116,439,496.00
35440	Түлш, шатах тослох материал	3,853,433.50	14,348,305.00
35450	Барилгын засварын материал	8,699,216.00	45,821,300.00
35460	Хүнсний материал	1,897,578.00	4,179,463.00
35470	Бусад хангамжийн материал	1,150,608,459.62	1,250,409,667.92
35600	Мал амьтад	2,110,000.00	3,345,000.00
2	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН БУС	<u>2,810,338,164.84</u>	<u>9,440,470,555.86</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,810,338,164.84	9,440,470,555.86
392	Биет хөрөнгө	2,810,338,164.84	9,405,599,981.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,069,243,260.00	7,776,759,610.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	2,232,823,269.42	88,478,538.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,025,678,543.50	5,712,508,435.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	622,281,407.15	4,756,130,823.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,672,750.32	3,811,225,983.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	69,266,686.49	3,088,796,919.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,530,673.78	186,268,436.65

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	118,447,708.64	150,714,149.64
39209	Зам, гүүрийн байгууламж		2,496,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл		2,496,000.00
39217	Ном	2,803,947.96	2,957,947.96
393	Биет бус хөрөнгө	-	34,870,574.79
39301	Програм хангамж	1,425,000.00	3,804,050.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,425,000.00	3,698,633.21
39303	Бусад биет бус хөрөнгө		34,765,158.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,033,535,018.84</u>	<u>11,009,607,236.16</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,033,535,018.84</u>	<u>11,009,607,236.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,033,535,018.84	11,009,607,236.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,137,492,525.87	4,172,257,683.87
51101	Өмч: - төрийн	4,137,492,525.87	4,172,257,683.87
512	Хуримтлагдсан үр дүн	(1,028,031,284.17)	360,785,329.84
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,028,031,284.17)	(1,028,644,483.83)
51220	Тайлант үеийн үр дүн		1,389,429,813.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	924,073,777.14	6,476,564,222.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,033,535,018.84</u>	<u>11,009,607,236.16</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,236,509,873.01	6,235,133,288.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	393,058,855.38	2,222,473,477.52
120	Нийтлэг татварын бус орлого	393,058,855.38	2,222,473,477.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	392,113,855.38	2,197,387,297.57
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		21,868,074.96
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	392,113,855.38	2,175,519,222.61
120009	Бусад орлого	945,000.00	25,086,179.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,843,451,017.63	4,012,659,811.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,825,627,004.63	3,768,662,851.45

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,022,820,600.00	3,947,725,900.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	(197,193,595.37)	(179,063,048.55)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,824,013.00	243,996,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,529,813.00	243,996,960.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,677,752,838.01	4,792,778,821.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,677,752,838.01	4,792,778,821.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,607,952,838.01	4,786,047,021.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,288,999,137.00	3,103,496,638.16
210101	Үндсэн цалин	1,470,979,988.00	1,412,031,035.55
210102	Нэмэгдэл	577,397,545.00	991,094,342.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,556,007.00	91,355,923.00
210105	Гэрээт ажлын хөлс	146,065,597.00	609,015,337.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,310,064.00	167,271,145.09
210201	Тэтгэврийн даатгал	68,856,730.00	84,166,154.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,918,338.00	10,520,769.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,836,675.00	8,416,615.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,918,338.00	2,104,155.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,779,983.00	62,063,452.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,668,873.17	225,504,196.51
210301	Гэрэл, цахилгаан	24,972,947.00	48,869,098.49
210302	Түлш, халаалт	130,643,500.00	168,901,168.28
210303	Цэвэр, бохир ус	1,052,426.17	7,733,929.74
2104	Хангамж, бараа материалын зардал	32,020,605.46	155,662,859.00
210401	Бичиг хэрэг	3,014,913.00	9,356,915.00
210402	Тээвэр, шатахуун	24,877,949.00	140,478,634.15
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,783,743.46	5,519,498.10
210404	Ном, хэвлэл		67,311.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		37,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,344,000.00	202,800.00
2105	Нормативт зардал	99,688,522.62	161,881,688.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,523,096.37	2,250,188.88
210502	Хоол, хүнс	10,600,737.00	8,211,905.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	87,564,689.25	151,419,594.15
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,075,245.00	119,007,843.25
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,951,833.00	28,969,632.25

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	20,387,862.00	90,038,211.00
2107	Томилолт, зочны зардал	10,607,300.00	170,090,300.00
210702	Дотоод албан томилолт	10,607,300.00	170,090,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,211,464.00	29,419,386.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,890,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,067,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,044,700.00	14,044,592.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,341,100.00	4,877,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	440,000.00	418,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,254,000.00	990,000.00
210807	Газрын төлбөр	6,131,664.00	6,131,664.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	830,371,626.76	653,712,965.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,636,500.00	4,773,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,363,776.00	97,722,695.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	718,371,350.76	551,217,085.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,800,000.00	6,731,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,800,000.00	6,731,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	6,731,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(441,242,965.00)</u>	<u>1,442,354,467.73</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	52,924,654.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		18,546,129.98
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		34,378,524.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(52,924,654.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(441,242,965.00)</u>	<u>1,389,429,813.67</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх гүйцэтгэл оны	Тайлант гүйцэтгэл оны /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,844,396,017.63	4,059,614,066.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	945,000.00	46,954,254.91
120	Нийтлэг татварын бус орлого	945,000.00	46,954,254.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	21,868,074.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		21,868,074.96
120009	Бусад орлого	945,000.00	25,086,179.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,843,451,017.63	4,012,659,811.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,825,627,004.63	3,768,662,851.45
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,022,820,600.00	3,947,725,900.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	(197,193,595.37)	(179,063,048.55)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,824,013.00	243,996,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,529,813.00	243,996,960.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,844,396,017.63	4,050,560,190.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,844,396,017.63	4,050,560,190.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,774,596,017.63	4,044,070,390.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,288,999,137.00	3,103,172,638.16
210101	Үндсэн цалин	1,471,082,018.00	1,954,990,606.16
210102	Нэмэгдэл	577,397,545.00	859,276,648.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,556,007.00	146,753,571.00
210105	Гэрээт ажлын хөлс	145,963,567.00	142,151,813.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,310,064.00	167,271,145.09
210201	Тэтгэврийн даатгал	68,856,730.00	84,166,154.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,918,338.00	10,520,769.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,836,675.00	8,416,615.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,918,338.00	2,104,155.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,779,983.00	62,063,452.09

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,867,493.17	222,919,318.01
210301	Гэрэл, цахилгаан	29,797,347.00	48,790,098.49
210302	Түлш, халаалт	111,267,720.00	166,395,289.78
210303	Цэвэр, бохир ус	802,426.17	7,733,929.74
2104	Хангамж, бараа материалын зардал	29,779,099.46	154,873,942.10
210401	Бичиг хэрэг	2,883,556.00	4,428,460.00
210402	Тээвэр, шатахуун	22,236,200.00	143,225,985.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,783,743.46	5,549,498.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		461,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,875,600.00	1,208,299.00
2105	Нормативт зардал	13,256,500.00	15,225,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,376,000.00	2,756,700.00
210502	Хоол, хүнс	8,885,200.00	9,740,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,995,300.00	2,728,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,389,111.00	65,963,203.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,185,849.00	6,197,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	435,000.00	541,300.00
210604	Урсгал засвар	5,768,262.00	59,224,103.00
2107	Томилолт, зочны зардал	10,607,300.00	171,661,100.00
210702	Дотоод албан томилолт	10,607,300.00	171,661,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,526,300.00	28,190,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,880,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,427,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,044,700.00	14,044,592.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,341,100.00	4,877,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	440,000.00	418,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	990,000.00
210807	Газрын төлбөр	7,710,500.00	4,552,828.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,861,013.00	114,792,794.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,611,813.00	2,673,000.00

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107,249,200.00	112,119,794.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,800,000.00	6,489,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,800,000.00	6,489,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	6,489,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	9,053,876.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,304,560.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,304,560.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,304,560.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,304,560.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,304,560.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	4,749,316.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-587,604,069.74		4,474,777,983.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			815,750.57		815,750.57
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-586,788,319.17	0.00	4,475,593,734.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-815,750.57			-815,750.57
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-441,242,965.00		-441,242,965.00
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	924,073,777.14	-1,028,031,284.17	0.00	4,033,535,018.84
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	923,258,026.57	-1,469,274,249.17	0.00	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-613,199.66		-613,199.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,137,492,525.87	924,073,777.14	-1,028,644,483.83	0.00	4,032,921,819.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		5,552,490,445.31			5,552,490,445.31
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	34,765,158.00				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,389,429,813.67		1,424,194,971.67
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,172,257,683.87	6,476,564,222.45	360,785,329.84	0.00	11,009,607,236.16

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,947,725,900.00	3,793,749,191.40	153,976,708.60	96.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,947,725,900.00	3,793,749,191.40	153,976,708.60	96.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,941,236,100.00	3,787,259,391.40	153,976,708.60	96.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,103,232,900.00	3,103,172,638.16	60,261.84	100.00
210101	Үндсэн цалин	2,020,085,300.00	1,954,990,606.16	65,094,693.84	96.78
210102	Нэмэгдэл	804,595,000.00	859,276,648.00	(54,681,648.00)	106.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	136,400,400.00	146,753,571.00	(10,353,171.00)	107.59
210105	Гэрээт ажлын хөлс	142,152,200.00	142,151,813.00	387.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	313,332,500.00	167,271,145.09	146,061,354.91	53.38
210201	Тэтгэврийн даатгал	178,113,600.00	84,166,154.00	93,947,446.00	47.25
210202	Тэтгэмжийн даатгал	27,466,100.00	10,520,769.00	16,945,331.00	38.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,095,000.00	8,416,615.00	23,678,385.00	26.22
210204	Ажилгүйдлийн даатгал	12,779,900.00	2,104,155.00	10,675,745.00	16.46
210205	Эрүүл мэндийн даатгал	62,877,900.00	62,063,452.09	814,447.91	98.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,455,000.00	217,190,159.05	3,264,840.95	98.52
210301	Гэрэл, цахилгаан	58,118,800.00	46,456,191.49	11,662,608.51	79.93
210302	Түлш, халаалт	159,595,600.00	166,395,289.78	(6,799,689.78)	104.26
210303	Цэвэр, бохир ус	2,740,600.00	4,338,677.78	(1,598,077.78)	158.31
2104	Хангамж, бараа материалын зардал	86,684,400.00	86,683,742.10	657.90	100.00
210401	Бичиг хэрэг	4,248,800.00	4,428,460.00	(179,660.00)	104.23

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21040 2	Тээвэр, шатахуун	75,086,300.00	75,173,485.00	(87,185.00)	100.1 2
21040 3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,737,100.00	5,549,498.10	187,601.90	96.73
21040 5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	324,300.00	324,000.00	300.00	99.91
21040 6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,287,900.00	1,208,299.00	79,601.00	93.82
2105	Нормативт зардал	15,225,700.00	15,225,700.00	-	100.0 0
21050 1	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,756,700.00	2,756,700.00	-	100.0 0
21050 2	Хоол, хүнс	9,740,800.00	9,740,800.00	-	100.0 0
21050 3	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,728,200.00	2,728,200.00	-	100.0 0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,892,000.00	54,890,863.00	1,137.00	100.0 0
21060 1	Багаж, техник, хэрэгсэл	9,826,800.00	9,898,360.00	(71,560.00)	100.7 3
21060 3	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,069,200.00	541,300.00	527,900.00	50.63
21060 4	Урсгал засвар	43,996,000.00	44,451,203.00	(455,203.00)	101.0 3
2107	Томилолт, зочны зардал	2,431,800.00	2,431,800.00	-	100.0 0
21070 2	Дотоод албан томилолт	2,431,800.00	2,431,800.00	-	100.0 0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,899,000.00	26,310,550.00	4,588,450.00	85.15
21080 2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,928,500.00	1,427,600.00	500,900.00	74.03
21080 3	Даатгалын үйлчилгээ	14,044,700.00	14,044,592.00	108.00	100.0 0
21080 4	Тээврийн хэрэгслийн татвар	5,489,400.00	4,877,530.00	611,870.00	88.85
21080 5	Тээврийн хэрэгслийн оношлогоо	475,200.00	418,000.00	57,200.00	87.96
21080 6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	990,000.00	-	100.0 0
21080 7	Газрын төлбөр	7,971,200.00	4,552,828.00	3,418,372.00	57.12

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Үндэсний аврах бригадын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,082,800.00	114,082,794.00	6.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,673,000.00	2,673,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,409,800.00	111,409,794.00	6.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,489,800.00	6,489,800.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,489,800.00	6,489,800.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,489,800.00	6,489,800.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,947,725,900.00	3,947,725,900.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,947,725,900.00	3,947,725,900.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,947,725,900.00	3,947,725,900.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	350.00	325.00	25.00	92.86
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	315.00	290.00	25.00	92.06
620003	Үйлчлэх ажилтан	34.00	34.00	-	100.00

4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	9	10
1	Цалингийн зардлыг шалгаж үзэхэд 30,445.4 мянган төгрөгийг спортын мастерын нэмэгдэлд үндэслэлгүйгээр олгосон, өөрийн орлогыг зарцуулахдаа 19.109.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,	49,555.0	Зөвлөмж	ҮАБ-ын захирагч Нягтлан бодогч	Д.Намсрай Г.Батбаатар
2	Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас 4,304.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тооллогоор дутагдсан 7.236.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлээгүй,	11,540.6	Зөвлөмж	ҮАБ-ын захирагч Нягтлан бодогч	Д.Намсрай Г.Батбаатар
3	Санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тулган баталгаажуулахад 832.8 мянган төгрөгийн авлагыг холбогдох байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,	832.8	Зөвлөмж	ҮАБ-ын захирагч Нягтлан бодогч	Д.Намсрай Г.Батбаатар
Нийт		61,928.4			